# АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:**


Дарга, тэргүүлэх аудитор
П.Төвсанаа
Утас:70592439

Аудитын менежер:
Х.Наранцацрал
Утас: 70592225

Ахлах аудитор:
Т.Батсайхан

Аудитор:
Б.Гантуяа
Т.Оюун-Эрдэнэ
Ж.Угтахбаяр

Утас: 70593113


## ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2018 оны 4 дүгээр сар

## Агуулга


АУДИТЫН ТАЙЛАН ........ 0

1 Аудитын гэрчилгээ ........ 4

2 Аудитын тайлан ........ 6

2.1 Оршил ........ 6

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 6

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 7

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 7

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 8

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 8

2.7 Тогтоосон материаллаг байдлын түвшин ........ 9

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9

2.8.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал ........ 9

2.8.2 Авлагын бүртгэл, тайлагнал ........ 10

2.8.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал ........ 13

2.8.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал ........ 14

2.8.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал: ........ 16

2.8.6 Орлогын бүртгэл, тайлагнал ........ 17

2.8.7 Зардлын бүртгэл, тайлагнал: ........ 20

2.8.8 Эм эргэлтийн сангийн бүртгэл, тайлагнал: ........ 22

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ........ 24

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 26

2.11 Шилэн дансны тухай мэдээлэл ........ 26

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 26

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 27

3 Менежментийн захидал ........ 28

Асуудал 1: Санхүүгийн тайлагнал Тэргүүлэх ач холбогдол-1 ........ 28

Асуудал 2: Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлага Тэргүүлэх ач холбогдол-1 ........ 29

Асуудал 3: Авлага. Тэргүүлэх ач холбогдол -1 ........ 30

Асуудал 4: Дотоод хяналт Тэргүүлэх ач холбогдол-1 ........ 30

4 Аудит хийгдсэн Санхүүгийн тайлан ........ 31

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

ДУА-2018/1/СТА-ТЕЗ

# Товчилсон үгс

| | |
|---|---|
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| СТАУС | Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ОНТБ | Орон нутгийн төсвийн байгууллага |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| БХӨТ | Богино хугацаат өр төлбөр |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТЗС | Тусгай зориулалтын сан |
| ЭЭС | Эм эргэлтийн сан |
| МХС | Мал хамгаалах сан |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| БМӨЭ | Боржигон мандал өрхийн эмнэлэг |
| ТТХТ | Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр |
| БХС | Байгаль хамгаалах сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| СХС | Сум хөгжүүлэх сан |

# 1 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
48090 , Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail:dundgovi@audit.gov.mn

2018.04.19 № 97

танай ____________ -ны №______________-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаардлаг.

Аудитаар Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит /ДУА-2018/1/СТА-ТЕЗ/ хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан заавар, журам, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсөв захирагч төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 04 дүгээр сарын 18–ны хооронд хийж, аудитын тайланг 04 дүгээр сарын 19-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгч байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлэв.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангаа 2018 оны 04 дугаар сарын 02-ны өдөр төрийн аудитын байгууллагад /2018.03.30-ний өдрийн 1/326 дугаар албан бичгээр/ ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам", гарын авлагын дагуу аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем /СТАУС/-д оруулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Санхүүгийн аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэж, үе шатны ажил тус бүрт чанарын хяналт хийж баталгаажуулсан.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, УСНББОУС болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг шалгуур болгон ашиглав.

## 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад, дотоод орчны талаар ойлголт олж авахын тулд тухайн салбарт дагаж мөрддөг хууль, журмыг судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

**Байгууллагын зорилго:** Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд:

- Аймгийн эдийн засаг, нийгмийг төр засгийн бодлогод нийцүүлэн уялдаа холбоог хангаж, тэнцвэртэй хөгжүүлэх;
- Орон нутгийн онцлог байдалд тохирсон хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох;
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлж, байгаль орчны зохистой бодлого явуулснаар бизнес хөгжих таатай орчныг бүрдүүлэх;
- Орон нутгийн нөөц, боломжид тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Уул уурхай, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг шинэ салбаруудыг хурдацтай хөгжүүлнэ гэсэн зорилго, зорилтуудыг тусгасан байна.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч төсөв захирагчийн хувьд дараах хуулиуд болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэх" журам.

Тайлант хугацаанд төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас 29 дүгээр тогтоолыг баталсан байна.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 114 төсөвт байгууллага, 189 төсөл сан, 16 орон нутгийн ерөнхий орлого, 19 ОНӨААТҮГ нийт 338 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна. Энэ нь Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хяналт, шалгалтыг тайлант хугацаатай уялдуулаагүй, өмнөх үеийг хамруулж байгаагаас шалтгаалж байна.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд Сангийн яамны "Э-тайлан" санхүүгийн цахим программ хангамж ашиглажээ.

## 2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар дараах маягтуудаар баримтжуулав.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх ойлголт болон цуглуулсан мэдээлэлд үндэслэн эрсдэлийн үнэлгээний горимоор 1 эрсдэлтэй асуудал тодорхойлж, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэн, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудлыг дахин нарийвчлан үнэлэхэд эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## 2.7 ТОГТООСОН МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,182.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 491.8 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 1 чиглэлээр 1 эрсдэлтэй асуудалд 3 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүнг /ТАБ-СТА-В-4.1/ маягтаар баримтжуулав.

Харин аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийг дунд гэж тооцсон, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй, аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

### 2.8.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл, ОНӨААТҮГ-ын арилжааны банкан дахь төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл;
- Кассад байгаа бэлэн мөнгө;
- Арилжааны банкуудад байршдаг орон нутгийн орлогын харилцах дансдын үлдэгдэл.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эхэнд 3,511.6 сая төгрөг байсан бол оны эцэст 2.765,7 сая төгрөг болж 21.2 хувиар буурчээ. Нийт үлдэгдлийн 3.8 хувь буюу 106.9 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтцээр харуулбал:**

*(сая төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Кассад байгаа бэлэн мөнгө | Банкинд байгаа бэлэн мөнгө | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Арилжааны банк | Төрийн сангийн нэгдсэн данс |
| Кассад байгаа бэлэн мөнгө | 3.5 | 1.1 | 1.1 | | |
| - Төгрөг | 3.5 | 1.1 | 1.1 | | |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 3,508.1 | 2,764.6 | - | **106.9** | 2,657.7 |
| - Төрийн сангийн харилцах | 3,370.0 | 2,657.7 | - | - | 2,657.7 |
| - Арилжааны банк дахь харилцах | 138.1 | 98.3 | - | 98.3 | |
| - Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.0 | 8.6 | - | **8.6** | - |
| **Нийт мөнгөн хөрөнгийн дүн** | **3,511.6** | **2,765.7** | **1.1** | **106.9** | **2,657.7** |

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал кассад байгаа бэлэн мөнгө 2.4 сая төгрөгөөр, банканд байгаа бэлэн мөнгө 31.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

**Төрийн санд байршиж буй харилцах дансдын үлдэгдлийг сумд болон төрлөөр хураангуйлан харуулбал:**

*(сая төгрөгөөр)*

| № | Байгууллагын нэрс | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | Адаацаг сум | 130.5 | 93.0 |
| 2 | Баянжаргалан сум | 206.1 | 261.6 |
| 3 | Говь-Угтаал сум | 134.1 | 115.1 |
| 4 | Гурвансайхан сум | 89.7 | 83.9 |
| 5 | Дэлгэрцогт сум | 71.4 | 51.1 |
| 6 | Дэрэн сум | 159.7 | 188.3 |
| 7 | Дэлгэрхангай сум | 71.5 | 108.7 |
| 8 | Цагаандэлгэр сум | 136.8 | 149.4 |
| 9 | Өндөршил сум | 162.7 | 62.0 |
| 10 | Өлзийт сум | 174.8 | 183.6 |
| 11 | Сайхан-Овоо сум | 29.4 | 69.2 |
| 12 | Сайнцагаан сум | 316.1 | 161.2 |
| 13 | Хулд сум | 41.1 | 50.0 |
| 14 | Луус сум | 85.3 | 101.3 |
| 15 | Эрдэнэдалай сум | 148.5 | 175.9 |
| 16 | ОНТБ-ууд | 1,553.8 | 911.3 |
| | | | |
| **Дүн** | | **3,511.6** | **2,765.7** |

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 21.2 хувь буюу 745.9 сая төгрөгөөр буурсан байна.

## 2.8.2 Авлагын бүртгэл, тайлагнал

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 8,631.7 сая төгрөг, оны эцэст 8,713.7 сая төгрөгөөр тус тус тайлагнагдсан байна.

**Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:**

*/сая төгрөгөөр/*

| Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он | Өсөлт / (Бууралт) | Эзлэх хувь /2017/ |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 8.6 | 8.3 | -0.4 | 0.1 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 15.1 | 7.0 | -8.1 | 0.1 |
| Дансны авлага / ОНӨААТҮГ / | 90.3 | 106.0 | 15.7 | 1.2 |
| Татвар НДШ / ОНӨААТҮГ / | 0.7 | 0.6 | -0.1 | 0.0 |
| Байгууллагаас авах авлага | 1,335.7 | 1,530.4 | 194.6 | 17.6 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 2,125.9 | 1,501.2 | -624.7 | 17.2 |
| Зээлийн хүүгийн авлага | 82.2 | 96.9 | 14.7 | 1.1 |
| ЗГ бусад шатны төсөвт олгосон зээл | 4,084.6 | 4,084.6 | 0.0 | 46.9 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 658.8 | 613.8 | -45.0 | 7.0 |
| Хувийн хэвшлийн ААНБ олгосон зээл | 229.8 | 765.0 | 535.2 | 8.8 |
| **Нийт дүн** | **8,631.8** | **8,713.7** | **81.9** | **100** |

Дээрх судалгаанаас харахад тайлант оны авлагын үлдэгдэл өмнөх оноос 81.9 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлагын эхний үлдэгдэл 4,084.6 сая төгрөгийг тохируулан устгах бичилт хийж 5.2 сая төгрөгөөр тайлагнасан буюу тайлант оны хорогдсон авлагыг 4,079.4 сая төгрөгөөр сөрөг тохируулан тайлагнасантай холбоотой байна.

Устгах бичилт нь УСНББОУС 6 дугаар стандарт Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн 46-д /Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондын тооцооны үлдэгдэл, ажил гүйлгээ буюу төстэй хуваарилалтыг хамруулах бөгөөд тэдгээрийг бүрэн устгана/ заасны дагуу хийгджээ.

Нийт авлагын ихэнх хувийг буюу 46.9 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага, 36.9 хувийг Сум хөгжүүлэх сангийн авлага /байгууллагаас авах авлага, хувь хүмүүсээс авах авлага, хувийн хэвшлийн ААНБ-д олгосон зээл / эзэлж байна.

**Авлагын үлдэгдэл, өсөлт, бууралтыг төсвийн захирагч тус бүрээр харуулбал:**

*/сая төгрөгөөр/*

| Төсөв захирагч | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ОНТБ, ОНӨААТҮГ | 4,970.4 | 5,021.2 | 50.8 | 57.6 |
| Дэлгэрцогт | 173.8 | 189.1 | 15.3 | 2.2 |
| Дэрэн | 183.8 | 138.7 | -45.1 | 1.6 |
| Говь-Угтаал | 112.1 | 187.0 | 74.9 | 2.1 |
| Цагаандэлгэр | 186.3 | 117.5 | -68.8 | 1.3 |
| Баянжаргалан | 204.3 | 181.9 | -22.4 | 2.1 |
| Өндөршил | 133.6 | 231.5 | 97.9 | 2.7 |
| Гурвансайхан | 245.3 | 212.5 | -32.8 | 2.4 |
| Өлзийт | 180.4 | 117.5 | -62.9 | 1.3 |
| Хулд | 183.3 | 217.0 | 33.7 | 2.5 |
| Луус | 170.1 | 168.3 | -1.8 | 1.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дэлгэрхангай | 212.6 | 176.3 | -36.3 | 2.0 |
| Сайхан-Овоо | 220.3 | 228.0 | 7.7 | 2.6 |
| Эрдэнэдалай | 381.6 | 297.3 | -84.3 | 3.4 |
| Сайнцагаан | 886.9 | 1,020.3 | 133.4 | 11.7 |
| Адаацаг | 186.8 | 209.5 | 22.7 | 2.4 |
| **Нийт дүн** | **8,631.8** | **8,713.7** | **81.9** | **100.0** |

Нийт авлагын 42.4 хувийг сумдын төсөвт байгууллага, төсөл сангийн авлага, 57.6 хувийг ОНӨААТҮГ-ууд болон аймгийн төвийн төсвийн байгууллагуудын авлага эзэлж байна.

Авлагыг насжилтаар нь судалж үзвэл 2007 оноос өмнө үүссэн 2,229.8 сая, 2007-2009 онуудад нэмэгдсэн 1.9 сая, 2010-2012 онуудад нэмэгдсэн 211.1 сая, 2013-2016 онуудад нэмэгдсэн 5,118.2 сая, 2017 онд шинээр нэмэгдсэн 1,152.4 сая төгрөгийн авлага байна.




Авлагын насжилтыг хувиар илэрхийлбэл нийт авлагын 26 хувь нь 120 сараас дээш, 4 хувь нь 48-84 сарын, 59 хувь нь 12-48 сарын, 13 хувь нь 1-12 сарын насжилттай байна.

Өндөр буюу 120 сараас дээш насжилттай авлагын 98.5 хувийг Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын "Хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл"-ийн авлага эзэлжээ.

Сумд Сум хөгжүүлэх сангаас төсөл хэрэгжүүлэгч ААНБ болон иргэдэд олгосон зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

**Авлага данстай холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар:**

Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бүртгэлийг аккруэл сууриар бүртгээгүй зэрэг нийтлэг алдаа зөрчлүүд илэрснээс гадна насжилт өндөртэй авлагын дүн өмнөх оноос төдийлөн буураагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө*/ 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/, 20.2.6-д /*Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах*/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*/ заасныг тус тус зөрчиж байна.

Дээрх алдаа зөрчлүүд нь холбогдох стандарт, хууль, дүрэм, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, найдваргүй авлага өсөх, зээлийн эргэн төлөлт хугацаандаа төвлөрүүлээгүйгээс Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах, хөрөнгийн хүртээмж, үр ашиг буурах зэрэг сөрөг үр дагаварууд бий болгож байна.

Цаашид УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, тэдгээртэй холбогдон гарсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

### 2.8.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 5,503.5 сая төгрөг байсан бол жилийн эцэст 6,104.7 сая төгрөг болж 601.2 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд бараа материалын данс нь 5,529.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс 85.9 хувь нь худалдан авалт, 7.2 хувь нь хандив, 0.6 хувь нь шилжүүлэн авсан, 6.2 хувь нь бусад эх үүсвэр байна.

**Бараа материалын өсөлт, бууралтыг харуулбал:**

*(сая.төгрөгөөр)*

| Бараа материал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, (бууралт) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 1,324.4 | 1,456.6 | 132.2 |
| Эм боох материал | 126.0 | 129.9 | 3.9 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 10.9 | 6.8 | (4.1) |
| Бичиг хэргийн материал | 189.2 | 182.2 | (7.0) |
| Аж ахуйн материал | 1,515.9 | 1,727.4 | 211.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 41.5 | 47.6 | 6.1 |
| Түлш, шатах тослох материал | 125.0 | 112.5 | (12.5) |
| Барилгын засварын материал | 238.2 | 318.8 | 80.6 |
| Хүнсний материал | 137.4 | 122.6 | (14.8) |
| Бусад хангамжийн материал | 685.8 | 879.8 | 194.0 |
| Мал амьтад | 1,099.2 | 1,104.1 | 4.8 |
| Нөөцийн бараа | 10.1 | 16.4 | 6.5 |
| **Нийт дүн** | **5,503.5** | **6,104.7** | **601.2** |

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын өсөлтийн ихэнх хувийг тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, барилгын засварын материал, бусад хангамжийн материалууд тус тус эзэлж байна.

**Бараа материалын үлдэгдэлд дансдын болон байгуулагуудын эзлэх хувийг диаграммаар харуулбал:**







Нийт бараа материалын 55.5 хувийг хангамжийн материал, харин 76 хувийг сумдын төсвийн байгууллагуудын бараа материал эзэлж байна.




ОНӨААТҮГ-уудын бараа материалын эхний үлдэгдэл 431.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 22.8 хувиар буюу 529.6 сая төгрөг болж өссөн байна. Нийт бараа материалын 62.7 хувийг Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант онд бараа материалын данстай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

*(сая.төгрөгөөр)*

| Зөрчлийн агуулга | Зөрчлийн дүн |
|---|---|
| Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалаар батлагдсан цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны норм норматив мөрдөж ажиллаагүй | 61.1 |
| Шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, анхан шатны баримтын бүрдэлгүй | 71.4 |
| Хяналтын тооллогоор бараа материал дутагдсан | 11.1 |
| Бараа материалын бүртгэлтэй холбоотой алдаа | 36.6 |
| Бараа материалыг зориулалт бусаар зарцуулсан | 0.8 |
| Хагас жилийн эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй /Дундговь-Ус/ | 259.9 |
| **Нийт дүн** | **441.0** |

Дээрх алдаа зөрчлүүд нь холбогдох стандарт, хууль, дүрэм, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, ажлын хариуцлага, дотоод хяналт сулрах, хөрөнгө дутагдах, үрэгдэх зэрэг сөрөг үр дагаваруудыг бий болгож байна.

Цаашид УСНББОУС-12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эдгээртэй холбогдон гарсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

### 2.8.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө 2017 оны эхэнд 139,981.9 сая төгрөг байсан бол тайлангийн хугацаанд 2.8 хувь буюу 3,959.0 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 143,940.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

*(сая төгрөгөөр)*

| № | Ангилал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, (бууралт) |
|---|---|---|---|---|
| 1 | Барилга байгууламж | 114,609.2 | 118,337.3 | 3,728.1 |
| 2 | Тээврийн хэрэгсэл | 4,742.5 | 4,771.0 | 28.5 |
| 3 | Машин тоног төхөөрөмж | 8,583.4 | 9,158.7 | 575.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **4** | Тавилга эд хогшил | 4,196.0 | 4,410.4 | 214.4 |
| **5** | Дуусаагүй барилга | 3,130.9 | 2,476.8 | (654.1) |
| **6** | Зам, гүүрийн байгууламж | 22.9 | 22.9 | - |
| **7** | Батлан хамгаалах тоног төхөөрөмж | 5.6 | 5.6 | - |
| **8** | Түүх соёлын дурсгалт зүйл | 881.3 | 887.3 | 6.0 |
| **9** | Номын фонд | 520.4 | 552.4 | 32.0 |
| **10** | Биет бус хөрөнгө | 151.9 | 153.1 | 1.2 |
| **11** | Бусад үндсэн хөрөнгө | 3,137.8 | 3,165.4 | 27.6 |
| | **Дүн** | **139,981.9** | **143,940.9** | **3,959.0** |

Нийт үндсэн хөрөнгийн 82.2 хувийг барилга байгууламж, 3.0 хувийг тавилга, эд хогшил, 6.4 хувийг машин тоног төхөөрөмж, 1.7 хувийг дуусаагүй барилга, 3.3 хувийг тээврийн хэрэгсэл, 2.2 хувийг бусад үндсэн хөрөнгө, 0.6 хувийг түүх соёлын дурсгалт зүйл, 0.5 хувийг номын фонд, батлан хамгаалах тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө, зам гүүрийн байгууламж тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 8,311.0 сая төгрөгөөр /*үнээс худалдан авсан 491.8 сая, хандив тусламжаар 2,001.2 сая, шилжүүлж авсан 2,643.7 сая, бусад 3,174.3 сая*/ нэмэгдэж, 4,352.0 сая төгрөгөөр /*акталсан 1,301.3 сая, шилжүүлсэн 2,335.0 сая, бусад 715.7 сая*/ хасагдаж, 5,753.0 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Тайлант онд 7,819.3 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авснаас төсөвт байгууллагад 7,478.6 сая төгрөгийн, ОНӨААТҮГ-т 340.7 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн байна.

Харин үндсэн хөрөнгийн данснаас 4,352.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1,300.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг хассан байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн алдаанаас үүссэн элэгдлийн зөрүү 677.5 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүнд бичилт хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:




Нийт үндсэн хөрөнгийн 131,132.1 сая төгрөг буюу 91.1 хувийг төсөвт байгууллагын, 12,784.5 сая төгрөг буюу 8.9 хувийг ОНӨААТҮГ-ын, 24.4 сая төгрөг буюу 0.02 хувийг төсөл сангийн хөрөнгө тус тус эзэлж байна.

**Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:**

Аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Тооллогыг чанаргүй зохион байгуулж, тооцоо бодож, баталгаажуулаагүй;
- Барилгын их засварыг өөрийн өртөгт нэмж капиталжуулаагүй;

- Хөрөнгийг анх олж бэлтгэхдээ буруу ангилан бүртгэсэн;
- Хөрөнгө дутагдуулсан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тайлагнасан гэх мэт.

Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлан, тодруулга буруу илэрхийлэгдэх материаллаг нөлөөтэй эрсдэлийг үүсгэж байна. Цаашид хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах, тооллогыг чанартай зохион байгуулах, үндсэн хөрөнгийн тооллогоор гарсан зөрүүг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж нягтлан бодох бүртгэлд тусгаж байх нь зүйтэй.

### 2.8.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал:

Тайлант онд 9,017.3 сая төгрөгийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 107.3 сая төгрөгөөр буурч оны эцэст 8,910.1 сая төгрөг болсон байна. Энэ нь богино хугацаат өр төлбөрийн бууралттай холбоотой байна.

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, (бууралт) |
|---|---|---|---|
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 858.5 | 751.3 | (107.3) |
| Өглөг | 858.5 | 751.3 | (107.3) |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 11.1 | 19.3 | 8.2 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 24.2 | 55.7 | 31.6 |
| Бусад өглөг | 823.3 | 676.3 | (147.0) |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 8,158.8 | 8,158.8 | - |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 8,158.8 | 8,158.8 | - |
| **НИЙТ ДҮН** | **9,017.3** | **8,910.1** | **(107.3)** |

**Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 751.3 сая төгрөгийг дансдын төрөл болон байгууллагын эзлэх хувиар харуулбал:**







Тайлант оны эцэст 751.3 сая төгрөгийн БХӨТ бүртгэгдсэний 90.0 хувь бусад өр төлбөр, 7.4 хувь нь бараа үйлчилгээний зардлын өр төлбөр, 2.6 хувь нь ажилчидтай холбогдсон өр төлбөр байна.

Мөн нийт БХӨТ-ийн 48 хувийг ОНХС, ТЗС, 34 хувийг сумдын төсөвт байгууллага, төсөл сангийн, 17 хувийг ОНӨААТҮГ-ын, 1 хувийг аймгийн төвийн төсвийн байгууллагын өр төлбөр тус тус эзэлж байна.

Нийт өр төлбөрийн 91.6 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байгаа бөгөөд энэ нь "Дундговь-Ус" ОНӨААТҮГ болон Гурвансайхан сумын 4,079.4 сая төгрөгийн өр төлбөрийг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын тайланд Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт төлөх өр төлбөрөөр бүртгэн устгах бичилт хийгээгүйгээс 8,158.8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Аудитаар өр төлбөрийн данстай холбоотой 7.8 сая төгрөгийн зөрчлүүд илэрснээс санхүүгийн тайланд 4.1 сая төгрөгийн өглөг тайлагнаагүй, харилцагч байгууллагуудтай 3.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчиж байна.

Цаашид УСНББОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, эдгээртэй холбогдон гарсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

### 2.8.6 Орлогын бүртгэл, тайлагнал

2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны орлогын нийт дүн 64,912.0 сая төгрөг байгаа нь өмнөх 2 оны мөн үетэй харьцуулахад 2015 оноос 15,991.2 сая төгрөгөөр, 2016 оноос 3,555.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

| Үзүүлэлт | 2015 он | 2016 он | 2017 он | Зөрүү 2015/2017 | Зөрүү 2016/2017 |
|---|---|---|---|---|---|
| Татварын орлого | 4,008.8 | 4,327.3 | 4,665.9 | 657.1 | 338.6 |
| Татварын бус орлого | 31,553.0 | 20,761.2 | 17,151.9 | -14,401.1 | -3,609.3 |
| Тусламж санхүүжилтийн орлого | 45,041.4 | 43,379.1 | 43,094.2 | -1,947.2 | -284.9 |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **80,603.2** | **68,467.6** | **64,912.0** | **-15,691.2** | **-3,555.6** |

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого өмнөх оноос 338.6 сая төгрөгөөр өссөн бол татварын бус орлого 3,609.3 сая төгрөгөөр, тусламж санхүүжилтийн орлого 284.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Орлогын үзүүлэлтүүдийг сүүлийн 3 оноор харьцуулан харуулбал:






Судалгаанаас харахад 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 4,665.9 сая төгрөг буюу 7 хувийг татварын орлого, 17,151.9 сая төгрөг буюу 27 хувийг татварын бус орлого, 66 хувь буюу 43,094.2 санхүүжилтийн орлого эзэлж байна.

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь харуулбал:

*/сая төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелсэн, (Тасарсан) |
|---|---|---|---|---|
| 1 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого | 3,487.2 | 3,455.9 | (31.3) |
| 2 | Үйл ажиллагааны орлого | 348.7 | 415.4 | 66.7 |
| 3 | Хөрөнгө борлуулсны орлого | 103.0 | 126.2 | 23.2 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (436.7) | (436.8) | (0.1) |
| 5 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 87.0 | 94.6 | 7.6 |
| 6 | Бууны албан татвар | 18.6 | 18.4 | (0.2) |
| 7 | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 220.0 | 238.5 | 18.5 |
| 8 | Улсын тэмдэгтийн хураамж | 123.8 | 150.2 | 26.4 |
| 9 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 21.0 | 22.8 | 1.8 |
| 10 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 29.6 | 30.4 | 0.8 |
| 11 | Газрын төлбөр | 190.0 | 183.4 | (6.6) |
| 12 | Дуудлага худалдаа | 50.0 | 22.6 | (27.4) |
| 13 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 280.3 | 278.9 | (1.4) |
| 14 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 46.0 | 28.8 | (17.2) |
| 15 | Бусад татвар | 40.0 | 36.5 | (3.5) |
| | **Татварын орлого** | **4,608.5** | **4,665.9** | **57.4** |

Тайлант хугацаанд 4,608.5 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,665.9 сая төгрөгийн орлого төвлөрч 83.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч дараах 7 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлогын төлөвлөгөөг 3,487.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,455.9 сая төгрөг төвлөрүүлж 31.3 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь цалин нэмэгдээгүй байхад өмнөх оноос төлөвлөгөөг 94.2 сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотой байна;
- Бууны албан татварыг 18.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 18.4 сая төгрөг төвлөрүүлэн, татварын орлого 0.2 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд галт зэвсгийн албан татварын орлогыг өндөр төлөвлөсөн бөгөөд Цагдаагийн газарт бүртгэлтэй буу

цөөн, галт зэвсгийн үзлэг явагдаж зөрчилтэй буунуудыг улсын орлого болгосонтой холбоотойгоор төлөвлөгөө тасарсан;

- Газрын төлбөрийг 190.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 183.4 сая төгрөг төвлөрүүлэн, төлбөрийн орлого 6.6 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь холбогдох албан тушаалтнууд холбогдох хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс шалтгаалсан байна;
- Дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 22.6 сая төгрөг төвлөрүүлэн, орлого 27.4 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд газрын дуудлага худалдаа зохион байгуулаагүй нь орлого тасрах шалтгаан болсон байна;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 17.2 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсонтой холбоотой байна;

- Ан амьтны нөөц ашигласны төлбөр, бусад татварын орлогыг нийт 320.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 315.4 сая төгрөгийг төвлөрүүлэн 4.9 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого тасарсан шалтгаан нь орлогыг бодитой төлөвлөөгүйгээс гадна төлөвлөгөө биелүүлэх талаар дорвитой ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

**Орлоготой холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүртгээгүй, харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй, шийдвэргүй зарцуулсан, зарцуулалтын тайлан гаргаагүй, түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зэрэг нийт 4.4 сая төгрөгийн зөрчлүүд илэрлээ. Эдгээр зөрчил нь дараах хууль, журмыг зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө*/, 14.4-т /*нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*/, мөн хуулийн 14.4.1-т /*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*/, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д /*Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дах бүртгэлийн дансанд тушаана*/, Аймгийн Засаг даргын 2009 оны 3 дугаар сарын 10 өдрийн 97 дугаар захирамжаар батлагдсан "Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам"-ын 1.3 /*Үнэт цаас, тасалбарын маягтын зарцуулалт, тайлагнал*/, тухайн үед мөрдөгдөж байсан ймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт "Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 2.7-д /*Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 80 хувийг байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 20 хувийг төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ*/ заасныг тус тус зөрчсөн байна.

### 2.8.7 Зардлын бүртгэл, тайлагнал:

**Зардлын бүтцийн талаар**

Тайлант онд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 62,667.7 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 1,673.4 сая төгрөгөөр буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нийт зардлыг өмнөх онтой харьцуулан сумдаар харуулбал:

*/сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Өмнөх он | Тайлант он | Өссөн (буурсан) | Тайлант оны зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дэлгэрцогт | 1,618.7 | 1,668.0 | 49.4 | 2.7 |
| 2 | Дэрэн | 1,808.5 | 1,776.9 | -31.7 | 2.8 |
| 3 | Говь-Угтаал | 1,424.2 | 1,489.4 | 65.2 | 2.4 |
| 4 | Цагаандэлгэр | 1,501.1 | 1,471.4 | -29.7 | 2.3 |
| 5 | Баянжаргалан | 1,597.6 | 1,690.5 | 92.9 | 2.7 |
| 6 | Өндөршил | 1,636.2 | 1,666.2 | 30.0 | 2.6 |
| 7 | Гурвансайхан | 2,159.3 | 2,360.8 | 201.5 | 3.8 |
| 8 | Өлзийт | 2,136.7 | 2,258.7 | 122.0 | 3.6 |
| 9 | Хулд | 1,766.6 | 1,853.8 | 87.3 | 3.0 |
| 10 | Луус | 1,571.5 | 1,569.0 | -2.6 | 2.5 |
| 11 | Дэлгэрхангай | 2,087.2 | 2,169.6 | 82.5 | 3.5 |
| 12 | Сайхан-Овоо | 1,950.6 | 1,861.4 | -89.2 | 3.0 |
| 13 | Эрдэнэдалай | 2,754.6 | 3,162.9 | 408.2 | 5.0 |
| 14 | Сайнцагаан | 9,941.9 | 10,182.9 | 241.0 | 16.2 |
| 15 | Адаацаг | 1,877.1 | 1,928.4 | 51.4 | 3.1 |
| 16 | Төрийн сан | 28,509.3 | 25,557.8 | -2,951.5 | 40.8 |
| | **Нийт дүн** | **64,341.1** | **62,667.7** | **-1,673.4** | **100.0** |

Сум тус бүрээр авч үзвэл Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайхан-Овоо сумд 2.6-89.2 саятөгрөгөөр буурч, бусад сумд 30.0-408.2 сая төгрөгөөр өсчээ.

Тайлант оны зардлын бүтцийг диаграмаар харуулбал:




Диаграмаас харахад нийт зардлын 18,394.2 сая төгрөг буюу 29.4 хувийг цалин, 16,295.3 сая төгрөг буюу 26.0 хувийг сумдад олгох татаас санхүүжилт, 14,631.9 сая төгрөг буюу 23.3 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан нь ихэнх хувийг эзэлж байна. 2016-2017 оныг харьцуулж харахад хангамж, бараа материалын зардал өмнөх

оноос 47.3 хувиар буурсан бусад зардал өмнөх оны гүйцэтгэлээс их хэмжээний өөрчлөлт гараагүй байна.

Зардлын данстай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хэмнэлтийн горим зөрчин төсвийн хөрөнгөөр хүндэтгэлийн арга хэмжээ болон байгууллагын ажилчдын дунд тэмцээн уралдаан зохион байгуулсан;
- Багш нарт 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 60 сар болоогүй байхад олгосон
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид урамшуулал олгосон;
- ОНХС-аас иргэдээс санал аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй ажлыг гүйцэтгэж, улсын төсвийн байгууллагыг санхүүжүүлсэн;
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардал, шагнал, урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт зэргийг үндсэн цалингийн сангаас төлсөн;
- ОНХС, СХС, БХС, Ахмадын сангуудаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан;
- Зардлуудыг зөрүүтэй тайлагнасан;
- Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн.

Дээрх зөрчлүүд нь Боловсролын тухай хуулийн 43.1.7-д /*Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох* /, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*/, Төрийн албаны тухай хуулийн 26.6-д /*Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно*/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.5-д /*Сангийн хөрөнгө нь сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана*/, Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын 1.1-д /*2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох*/, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд: /*Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын дагуу 2017 онд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгний урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /*анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 13.7-д /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*/, 20.1.4 /*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх*/заасныг тус тус зөрчсөн байна.

Харин дараах ноцтой зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төв хоолны зардлаас айраг худалдан авч эмч нарт зарцуулсан;
- Эрдэнэдалай сумын Соёлын төв, Биеийн тамир спортын хороо цалингийн сангаас "Бага олимп болон гамшгаас хамгаалах сургуулилт"-д оролцсон албан хаагчид урамшуулал олгосон;
- Өлзийт сумын Цэцэрлэг албан хаагчид олгох жирэмсэн амаржсаны тэтгэмжийг төлбөрийн хүсэлтэнд бичсэн дансанд шилжүүлээгүй няравын харилцахад шилжүүлэн, бэлнээр гарган авсан бөгөөд тухайн хүнд хугацаа хожимдуулж олгосон, хандиваар орж ирсэн мөнгийг төрийн сангийн харилцах дансаар оруулалгүйгээр няравын дансанд шилжүүлэн авч

шийдвэргүйгээр зарцуулж санхүүгийн тайланд гүйлгээг тусгалгүй зарцуулалтад хуурамч баримт бүрдүүлсэн;

- Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль бэлтгэн нийлүүлэгчийн санал болгосон нүүрсний хөнгөлөлтийн үнийг төсвөөс төрийн бус байгууллагад шилжүүлж түлш шатахууны зардлаар тайлагнасан;
- Аймгийн Засаг даргын Тамгын газар зарим албан тушаалтны ээлжийн амралтыг бүрэн эдлүүлэлгүй дутуу амралтын хоногоор тооцож мөнгөн урамшуулал олгосон, хувийн байгууллагад 21.4м$^2$ өрөө болон телевизийн тоног төхөөрөмжийг түрээсгүйгээр ашиглуулсан;
- Цагаандэлгэр сумын Байгаль хамгаалах сангаас Төрийн бус байгууллагын дансанд мөнгө шилжүүлэн гандан хийдийг засварлахад зориулан сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Сангаас хоолны мөнгө шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан.

Эдгээр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-т /*ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна*/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/ мөн хуулийн 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1-т /*тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд заасна ас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно*/ заасныг тус тус зөрчсөн.

Зардлын данстай холбоотой гарсан алдаа, зөрчлүүд нь төсөв захирагчдын дотоод хяналт хангалтгүй, ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлагаас шалтгаалан гарч байгаа бөгөөд төсөв хөрөнгө хяналтгүй үрэлгэн зарцуулагдах, ажлын хариуцлага сулрах, хууль тогтоомж зөрчигдөх эрсдэл, үр дагаварыг бий болгож байгаа тул цаашид хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах, мэдлэг ур чадвараа сайжруулах шаардлагатай байна.

### 2.8.8 Эм эргэлтийн сангийн бүртгэл, тайлагнал:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын Эмийн эргэлтийн сангийн 15 тайлан нэгтгэгдсэнийг Саруул Баян-Уул аудит ХХК гэрээгээр аудит хийж, 15 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Эмийн эргэлтийн сангууд нийт 53.2 сая төгрөгийн авлагын, 79.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь эм боох материалын тооцоотой холбоотойгоор үүссэн байна. Өмнөх оноос авлага 5.8 сая төгрөгөөр өссөн, өр төлбөр 2.3 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд Эм эргэлтийн сангууд нийт 829.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 807.2 сая төгрөгийн зарлагатай, 22.2 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Өмнөх оноос нийт дүнгээрээ борлуулалтын орлого 23.4 сая, зардал 37.0 сая төгрөгөөр тус тус өссөн, ашиг 13.6 сая төгрөгөөр буурчээ.

**Үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал**:

*/Сая төгрөгөөр/*

| № | Сумдын нэрс | Нийт орлого | Нийт зардал | Үүнээс | | | Ашиг /+/ алдагдал /-/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Цалин, НДШ | Эмийн зардал | Бусад зардал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дэлгэрцогт | 60.0 | 59.3 | 10.4 | 45.6 | 3.3 | 0.7 |
| 2 | Дэрэн | 69.3 | 64.5 | 9.1 | 51.8 | 3.6 | 4.8 |
| 3 | Говь-Угтаал | 43.7 | 43.3 | 8.0 | 33.0 | 2.3 | 0.4 |
| 4 | Цагаандэлгэр | 20.6 | 20.7 | 2.4 | 16.5 | 1.8 | -0.1 |
| 5 | Баянжаргалан | 38.3 | 36.9 | 5.8 | 29.2 | 1.9 | 1.4 |
| 6 | Өндөршил | 72.2 | 67.9 | 13.0 | 46.6 | 8.3 | 4.3 |
| 7 | Гурвансайхан | 58.9 | 56.9 | 10.0 | 42.2 | 4.8 | 2.0 |
| 8 | Өлзийт | 51.0 | 52.2 | 10.5 | 35.5 | 6.2 | -1.2 |
| 9 | Хулд | 31.4 | 36.2 | 5.6 | 27.7 | 2.9 | -4.8 |
| 10 | Луус | 48.6 | 47.6 | 11.2 | 31.6 | 4.8 | 1.0 |
| 11 | Дэлгэрхангай | 97.3 | 91.2 | 13.2 | 68.1 | 9.9 | 6.1 |
| 12 | Сайхан-Овоо | 55.6 | 54.4 | 6.9 | 43.9 | 3.6 | 1.2 |
| 13 | Эрдэнэдалай | 74.7 | 70.5 | 10.8 | 55.5 | 4.2 | 4.2 |
| 14 | Сайнцагаан | 43.9 | 40.9 | 6.2 | 33.5 | 1.2 | 3.0 |
| 15 | Адаацаг | 63.7 | 64.7 | 9.1 | 51.0 | 4.6 | -1.0 |
| Нийт дүн | | 829.2 | 807.2 | 132.2 | 611.7 | 63.3 | 22.0 |

Нийт 807.2 сая төгрөгийн зардал гарснаас 16.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 75.8 хувийг эмийн, 7.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна. Нийт дүнгээрээ 22.0 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч Цагаандэлгэр, Өлзийт, Хулд, Адаацаг сумдын Эмийн эргэлтийн сангууд 0.1-4.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Эм эргэлтийн сангуудын авлага өмнөх оноос 5.9 сая төгрөгөөр буюу 12.2 хувиар өсч, өр төлбөр 2.3 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурчээ.

Үүнийг сум тус бүрээр харуулбал: (*сая төгрөгөөр*)

| № | Сумдын нэр | авлага | | | өр төлбөр | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмнөх он | тайлант он | өсөлт, бууралт | өмнөх он | тайлант он | өсөлт, бууралт |
| 1 | Дэлгэрцогт | 0.5 | 0.4 | -0.1 | 1 | 0.5 | -0.4 |
| 2 | Дэрэн | 11.2 | 15.4 | 4.2 | 2.7 | 2.1 | -0.6 |
| 3 | Говь-Угтаал | 1.4 | 1.8 | 0.4 | 4.4 | 4.9 | 0.5 |
| 4 | Цагаандэлгэр | 2.7 | 1.4 | -1.3 | 12.6 | 11.3 | -1.3 |
| 5 | Баянжаргалан | 12.6 | 11.6 | -1.0 | 20.9 | 14.7 | -6.2 |
| 6 | Өндөршил | 0.2 | 0 | -0.2 | 6.1 | 2.3 | -3.8 |
| 7 | Гурвансайхан | 0.3 | 0.3 | 0 | 1.4 | 1.8 | 0.4 |
| 8 | Өлзийт | 0.3 | 0.6 | 0.2 | 5.3 | 6.9 | 1.6 |
| 9 | Хулд | 5.1 | 3.7 | -1.4 | 7.1 | 11.9 | 4.8 |
| 10 | Луус | 0.2 | 0.2 | 0 | 0.3 | 0.4 | 0.1 |
| 11 | Дэлгэрхангай | 0.2 | 0.7 | 0.5 | 0.5 | 0.2 | -0.3 |
| 12 | Сайхан-Овоо | 0.9 | 5.8 | 4.9 | 8.3 | 11.8 | 3.5 |
| 13 | Эрдэнэдалай | 1.9 | 2 | 0.1 | 2.4 | 5.1 | 2.7 |
| 14 | Сайнцагаан | 0.4 | 0.4 | 0 | 6.3 | 4.8 | -1.5 |
| 15 | Адаацаг | 9.6 | 9.1 | -0.4 | 2.8 | 0.9 | -1.9 |
| **Нийт дүн** | | **47.4** | **53.2** | **5.9** | **82** | **79.6** | **-2.3** |

Дээрх судалгаанаас үзэхэд Цагаандэлгэр, Хулд сумд өмнөх оноос 1.3-1.4 сая төгрөг буюу хамгийн их дүнгээр авлага бууруулсан байгаа бол Дэрэн, Сайхан-Овоо сумд 4.2-4.9 сая төгрөгөөр буюу хамгийн их дүнгээр авлагыг өсгөжээ.

Харин өр төлбөрийн хувьд Өндөршил, Баянжаргалан сумд 3.8-6.2 сая төгрөгөөр өр төлбөрийг хамгийн их дүнгээр барагдуулсан бол Сайхан-Овоо, Хулд сумд 3.5-4.8 сая төгрөгөөр буюу хамгийн их дүнгээр өсгөсөн үзүүлэлттэй байна.

Эдгээр үзүүлэлтүүдээс үзэхэд сумдын Эм эргэлтийн сангууд авлага, өр төлбөр нэмж үүсгэхгүй байх, өмнөх үлдэгдлийг барагдуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллавал нийт өр төлбөрийн 66.8 хувийг барагдуулах боломжтой байна.

Эм эргэлтийн сангуудаас тайлант онд Дэлгэрцогт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Сайнцагаан сумд орлого, зардлын төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан байгааг цаашид анхаарч, үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна.

## 2.9 АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Харин 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлан, тодруулга дахь алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

